

“Дорнод Авто зам” ХК-ийн 2014 оны үйлдвэрлэлийн ажлын тайлан

2014-1-14

“Дорнод Авто зам” ХК нь орон нутгийн болон аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа зэргэлдээх аймгууд болон ОХУ, БНХАУ-тай холбогддог замын 7 чиглэлд 1250 км улсын чанартай зам, 1228 у/м төмөр бетон гүүр, хоолойнуудын бэлэн байдал, зам гүүрийн засвар арчлалтын ажлыг хариуцан ажилладаг.

Тус компани нь 2014 онд үйл ажиллагааны үндсэн чиглэл болох хариуцсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх гэрээг ЗТЯ-тай байгуулан ажиллаж 7 чиглэлд батлагдсан төлөвлөгөөний дагуу 709.8 сая төгрөгийн засвар арчлалтын ажил, Улз, Хэрлэн,Халх голын 5 ш гүүрүүдийн хамгаалагчийн зардал 16.9 сая.төгрөг, шуурхай хэсгийн 21.1 сая төгрөг нийтдээ 747.8 сая төгрөгийн ажлыг графикт хугацаанд нь технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэлээ. Мөн төвийн 2.27 км асфальтан замын хучилтын ажил, явган хүний зам, тэмдэг тэмдэглэгээ зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Компаний зүгээс эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэхийн тулд үйлдвэрлэлийн бэлтгэлийг сайтар хангах, техникийн засварыг чанартай хийх, тухайн ажилд шаардлагатай материалаар хангах зэрэг ажлыг зөв зохион байгуулж ажилласан.

Тус компани нь 2014 онд Чойбалсан – Баян уул чиглэлийн замын засвар арчлалт, Галын голын төмөр бетон хоолой шинээр барих, Баян уул- Ульхан улсын хил хүртэлх, Баян уул-Өндөрхаан чиглэлийн замын засвар арчлалт болон гүүр хоолой засварлах, шинээр барих, Чойбалсан – Баруун Урт, Чойбалсан – Эрээнцав, Чойбалсан – Хавирга боомтын хил хүртэлх замын засвар арчлалт, Чойбалсан – Сүмбэр чиглэлийн замын засвар арчлалт, Халх гол – Сүмбэрийн Хамар давааны зам засварлах, төмөр бетон хоолой шинээр барих , бүх чиглэлийн замын тэмдэг тэмдэглэгээг шинээр хийх, сэргээх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тайлан бичсэн: Ерөнхий инженер

*Ч.Уянгабат*

Т.Үнэнбат